



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 4/196

Хэрлэн сум

Салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйл, Засгийн газрын 2016 оны 233 дугаар тогтоол, Шадар сайдын 2017 оны 43 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр", Монгол Улсын Шадар сайдын 2017 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 43 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор Засаг даргын дэргэд төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга:

-Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

-Хууль, эрх зүйн хэлтсийн хууль тогтоомжийн системчлэл, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

-Онцгой байдлын газрын орлогч дарга

-Мэргэжлийн хяналтын газрын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга

-Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга

-Аймгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн гүйцэтгэх захирал

-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтэц, төлөвлөлтийн бодлого хариуцсан мэргэжилтэн

-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн худалдаа үйлчилгээ, хүнс аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн

2//.

2. "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр", Шадар сайдын 2017 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 43 дугаар тушаалыг орон нутагт хэрэгжүүлэх орон тооны бус салбар зөвлөлийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг салбар зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА